

“МЕТАЛЛ КОППЕР” ХХК

Металл хог хаягдлыг дахин боловсруулж, зэс утас үйлдвэрлэх төсөл

**2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Батлав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам
хүрээлэн буй орчны бодлого
зохицуулалтын газрын дарга
Б.БУЯННЭМЭХ

/_____/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Металл Коппер”ХХК-ийн
захирал

/_____/

УЛААНБААТАР ХОТ СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
**МЕТАЛЛ ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛЖ, ЗЭС
УТАС ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: /6428924./

Хянасан:

БОАЖЯ, Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын
газрын мэргэжилтэн

/Солонго/

Боловсруулсан:

Металл КопперХХК-ийн

Менежер

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	2
1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ	2
1.3 ТӨСЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ	2
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	4
2.2 НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
Төслийн гол сөрөг нөлөөлөл.....	7
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	8
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	14
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
13. ДҮГНЭЛТ	18

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Металл Коппер” ХХК

Төслийн нэр: “Металл хог хаягдлыг дахин боловсруулж, зэс утас үйлдвэрлэх”

Улсын бүртгэлийн дугаар: 9011346133

Регистрийн дугаар: 6428924

Утас: 99985521

1.2 Төслийн байршил

“Металл Коппер” ХХК-ийн “Металл хог хаягдлыг дахин боловсруулах, зэс утас үйлдвэрлэх” төсөл нь засаг захиргааны хувиарлалтаар Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо, Жаргалант тосгон, Рашаант хэсэгт төв зам дагуу байрлана.



1.3 Төслийн зорилго, ач холбогдол

Төслийн зориолго: Металл хог хаягдлыг дахин боловсруулж зэс утас үйлдвэрлэж, хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангасан, чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх, бүтээгдэхүүний онцлогийг таниулах замаар зах зээлд бүрэн нэвтрэх, байгаль орчинд нөлөөлөх хог хаягдлын хор хөнөөлийг бууруулах, салбарын хөгжилд хувь нэмэр оруулах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортын орлогыг нэмэгдүүлэх, улс орныхоо хөгжил цэцэглэлтэнд хувь нэмэр оруулах, үйл ажиллагааны хүрээг тэлэн үнэ цэнийг нэмэгдүүлэх нь энэхүү төслийн эрхэм зорилго болно. I

Төслийн ач холбогдол: Энэхүү төслийг хэрэгжүүлснээр

2. Металл хог хаягдлыг дахин боловсруулж олон улсын шаардлагын дагуу зэс утас үйлдвэрлэх
3. Зэс утас үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
4. Тухайн салбарт олон улсын хэмжээнд шалгарсан бодит туршлагыг байгууллагын нөөц бололцоонд тулгаарлан үйл ажиллагаандаа тогтмол нэвтрүүлэх
5. Бүтээгдэхүүний чанарт онцгой анхаарч чанарыг сайжруулах
6. Сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, технологийн судалгаа тогтмол хийж үйлдвэрлэлд нэвтрүүлж байх.
7. Металл хог хаягдлын тархалтыг зогсоох
8. Цаашид бүтээгдэхүүний нэр төрлөө байнга нэмэгдүүлэн ажиллах
9. Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, 11 хүний байнгын ажлын байраар хангах.
10. Цаашид зэс утсаа шууд экспортонд гаргах биш утсаа бүрж уртасгагч залгуур зэргийг үйлдвэрлэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ
11. Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, оруулсан хөрөнгийн өгөөжийг боломжит дээд түвшинд байлгах
12. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах
13. Экспортын орлогыг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах
14. Байгаль орчныг хамгаалах үйлст хувь нэмрээ оруулах
15. Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Байгаль орчны төлөв байдал

“Металл Коппер” ХХК-ний Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутагт хэрэгжих “Металл хог хаягдалыг дахин боловсруулж, зэс утас үйлдвэрлэх” төслийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	
Газрын гадарга, байр зүй	Судалгааны талбай нь геоморфологийн хэв шинжийн хувьд, уулын бэл хормойн хурдас чулуулгийн зөөгдөл-хуримтлалын гадаргуугийн хэсэгт хамаарагдана. Төслийн газар нь далайн түвшинээс дээш 1290 м орших бөгөөд газарзүйн байрлал нь ХӨ, ЗУ " болно.
Уур амьсгалын нөхцөл	Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл Улаанбаатар хот орчим нь хуурайдуу сэрүүвтэр мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана. <u>Агаарын температур:</u> Тухайн бүс нутагт жилийн дундаж агаарын температур -4°C орчим байх ба хотын дотор (Тахилт, Улаан хуаран орчим) -1.2 ...-1.5°C, өндөр уулын оройгоор (Хүрэлтогоот, Морин уул) -1...0.8°C гэж одоо мөрдөж байгаа “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт. БНБД 2.01.01-93”-д гаргасан байна. Туул голын хөндийд -4...-4.20C, үүнээс ч хүйтэн, уулын энгэр, ээвэр газар -4°C-ээс дулаан, ар хойт талдаа үүнээс ч хүйтэн байх жишээтэй. Агаарын температур уул нуруундаа +14°C-аас сэрүүн, голын хөндий нутагт арай дулаан 14-16°C байна. <u>Агаарын чийгшил, хур түнадас:</u> Харьангуй чийгшил хамгийн дулаан сарын өдрийн 13 цагт 50-60 % байдаг нь энэ орчим нь өндөр чийгшилтэй нутаг юм. Жилийн дундаж харьцангуй 70-75 % хүрч хуурай хаврын улиралд 45-55 % байна. <u>Нарны цацраг, нарны гийгүүлэл:</u> Улаанбаатар хотод жилдээ 2862-2816 цаг нар гийгүүлэх бөгөөд Богд Хан ууланд дунджаар 2800 цаг нар гийгүүлдэг байна. <u>Хур түнадас:</u> Хур борооны дундаж эрчим зуны саруудад 0.05 мм/мин, хамгийн их эрчим VII сардаа 1.28 мм/мин байна. <u>Салхи, агаарын даралт:</u> Хан Хэнтийн нуруу, Туул голын сав газрын салхи нь хойт, баруун хойноос хойгоор шуудтай. Саруудын хамгийн их хурд 5 м/сек.

Агаар, дуу чимээ	• Уурын зуухнаас их хэмжээний утаа тортог гарах • Төслийн барилгын орчмын суларсан хөрс болон шороон замаас тоос шороо үүсэх; Төслийн талбайн шинээр барилга баригдсан байгаа учир одоогийн байдлаар төслийн талбайн цементэн хучаас болон ногоон байгууламж байгуулаагүй байгаа бөгөөд энэ нь үйлдвэр бүрэн баригдаж, ашиглалтанд орох үе хүртэл хүний хөл хөдөлгөөн болон машин механизмын хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх юм. Мөн хөдөлгүүрийн шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд агаарт дэгдэх зэргээр агаарын чанар, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайн орчны дуу чимээний хэмжилтийг 2020 оны 04 сарын 07-нд хийсэн. Хэмжилтийг төсөл хэрэгжих цэг дээр, байгалийн нөлөө /салхи/, хүний үйл ажиллагааны нөлөө /харилцан яриа, зам, ойролцоох үйлдвэр/ зэрэгхүчин зүйлийг тусган өнөөгийн бодит дуу чимээний түвшинг тодорхойлсон. Дуу чимээний дундаж утгын түвшин Монгол улсын МНЭ4585:2017 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байгаа ба дуу чимээний хамгийн их утга 80 дБ байхаас 64,4 дБ гарсан байна. Энэ нь тухайн үед төсөл нь үйл ажиллагаа явуулаагүй байсан бөгөөд төслийн ойр орчмын үйлдвэрийн дуу чимээ болон ойролцоох засмал зам дээр явсан тээвэрийн хэрэгсэлийн дуу чимээний нөлөө орсон байж болно. Төслийн үйл ажиллагаагаа явуулж эхлэх үед үйлдвэрийн дуу чимээний түвшин нэмэгдэж болох юм.
Ус	Төслийн талбай орчимд гадаргын ил задгай ус байхгүй учир гадаргын усны нөөц,
	чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байх боломжтой. Цаашид төсөл хэрэгжих үед үйлдвэрийн үйл ажиллагаанд газар доорх ус ашиглах бөгөөд гүний худаг гаргуулан ажиллах юм. Энэ нь гүний усанд нөлөөлөх нөлөөлөл болно.
Хөрс	• Төслийн үйл ажиллагааны явцад, машин техникийн хөдөлгөөн зэргээс шалтгаалж тус орчны зарим хэсгийн үржил шимт хөрс элэгдэл, эвдрэлд орох; • Машин, техникийн аюулгүй ажиллагаа алдагдах, тослох материалын асгаралт зэрэг нь хөрсөнд шууд нөлөөлөх
Ургамлан	Төслийн ойр орчим нь суурьшлийн бүс учраас хөрс эвдрэлд өртөж, үүссэн тоосжилт нь ургамлан бүрхэвч дээр бууж хуримтлагдсанаар ургамлын фотосинтезийн бүтээмжид сөргөөр нөлөөлж урт хугацаанд ургамлын ургах

Амьтан	Төслийн үйл ажиллагааны ойролцоо гэр хороолол, үйлдвэрүүд төвлөрсөн бүс учраас томоохон зэрлэг амьтад үргэн дайжсан бөгөөд тэдгээрт нөлөөлөл байхгүй
Тусгай хамгаалалттай газар	Төслийн талбай орчимд улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаггүй болно.

2.2 Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо буюу Жаргалант тосгоны үүсэл хөгжил нь анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1976 оны 12-р сарын 25-ны өдрийн 426-р тогтоолоор Партизан хороо, сангийн аж ахуй нэртэйгээр байгуулагджээ. Партизан хорооны Ардын Депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа нь 1977 оны 1-р сараас 1992 оны 10-р сар хүртэл 15 жил төр захиргааны үйл ажиллагааг явуулж ирсэн болно. Энэ хугацаанд орон нутгийн эрхийг барих дээд байгууллага нь Партизан хорооны Ардын депутатуудын хурал байсан юм.

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг үндэслэн Монгол Улсын УИХ-ын 1992 оны 46-р тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 25-р тогтоолын дагуу Партизан хороо нь 1992 оны 9-р сард Жаргалант дүүрэг болон өөрчилөгдөн зохион байгуулагдаж, 1995 оны 3-р сарын 11-нийг хүртэл үйл ажиллагааг явуулж иржээ. Нийслэл Улаанбаатар хотын Засаг захиргааны байгууллагын бүтэцийн өөрчлөлтөөр Монгол Улсын УИХ-ын 1995 оны 16, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 23, Нийслэлийн ИТХ-ын 1995 оны 13 дугаар тогтоолын дагуу Жаргалант дүүрэг татан буугдаж, одоогийн СХД-ийн 21-р хороо, Жаргалант тосгон байгуулагдсан түүхтэй.

Тус хороо, тосгонд 12 жилийн 74,121-р бүрэн дунд сургууль, 116-р цэцэрлэг, Төмөр замын Рашаант өртөөнд цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын ордон, Цагдаагийн тасаг, Хаан банкны Партизан тооцооны төв, Хадгаламж банкны Партизан тооцооны төв, Мал эмнэлгийн албад, эмийн сан, Төмөр замын өртөө зөрлөгүүд, амралт сувилалын газрууд, нийтийн хоол, худалдаа үйлчилгээний цэг салбарууд, хөдөө аж ахуй үйлдвэрлэлийн компани, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг.

Одоогийн байдлаар Засаг захиргааны анхан шатны нэгжийн хувьд хорооны ИНХ, хорооны Засаг дарга бөгөөд тосгоны Захирагчийн Ажлын Албанаас гадна 11 хэсгийн бүтэц, зохион байгуулалттайгаар төрийн албаны бүх төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна.

Одоо тус хороо, тосгон нь 84706 га нутаг дэвсгэртэй, 1870 өрхтэй, 6245 хүн ам, 47878 толгой мал, 14000 тахиа, 105 үхрийн хагас эрчимжсэн аж ахуй, сүү хүлээн авч

хөргөх болон сүү цагаан идээ боловсруулах цехтэй, усалгаатай газар тариалан эрхлэх, усан хангамжийг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, ХАА-н үйлдвэрлэлийн эрчимжсэн цогцолборыг хөгжүүлэн оршин суугч иргэдийнхээ ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулж, өрхийн амьжиргааны орлогыг дээшлүүлэх, орон нутгаа хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг өөрийн орон нутгийн бололцоо, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санаачлага, Нийслэл дүүргийн удирдлага, туслалцаанд түшиглэн явуулж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Металл Коппер” ХХК-ний Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутагт хэрэгжих “Металл хог хаягдлыг дахин боловсруулж, зэс утас үйлдвэрлэх” төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бус нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг төслийг хэрэгжүүлэх байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчлмсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг.

Үүнд:

Агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

Төслөөс газар шорооны ажлын улмаас агаарт тоосжилт үүсэх

Хийн алдагдал үүсэх болзошгүй нөхцөл

Усны чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

Байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.

Хөрсний чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан хөрс бохирдох.

Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.

Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

Төслийн гол сөрөг нөлөөлөл

№	Зэрэг	Тайлбар		
		Сөрөг нөлөөлөл	Хөрөнгө	Шийдэл
III	болзошгүй	Барилгын суурь бэлтгэх болон барилгын материал тээвэрлэх машинуудын хөдөлгөөнөөр тоосжилт	Н-Дунд хохирол	Цаг агаарын нөхцөлтэй уялдуулан зам
III	болзошгүй	Автомашин тос тослогооны бодисын тархалт	М-Бага хохирол	Үйл ажиллагааны хяналт, зохистой хэрэглээ
III	болзошгүй	Дуу чимээ, доргионы бохирдол	М-Бага хохирол	Техник, авто машины ажиллах давтамжмйг багасгах
IV	Магад болох	Ахуйн хатуу хаягдлын тархалт	Н-Дунд хохирол	Хатуу хог хаягдлын
IV	Магад болох	[Барилгын материалын хатуу хаягдал	Н-Дунд хохирол	зөв менежмент

М	магад болохгүй	Хийн тоног техөөрөмжийн суурилалтын аюулгүй байдлыг бүрэн хангаагүйн <u>улмаас үүсэх эрсдэл</u>	Дунд хохирол	Технологийн аюулгүй байдлыг чацд сахин ажиллах
---	----------------	---	--------------	--

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус төслийн өмнөх байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон төслийн талбайд хийсэн хээрийн судалгаа, шинжилгээний дүн зэргийг үндэслэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг боловсруулав. Тус төслийн 1 жилийн бүтээн байгуулалт болон цаашдын ашиглалтын 4 жилийн хугацаагаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөөний дагуу 2020-2025 оны хооронд болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөлүүдээс сайтар сэргийлэн ажиллах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх, хог хаягдлын сайтар бэлтгэгдсэн менежмент, зайлуулах устгах системтэй болох зэрэг байх болно.

- Барилга баригдах үйл ажиллагаатай холбоотой тоосжилтийг бууруулах
- Болзошгүй эрсдэл, үерийн үед ажиллах төлөвлөгөөтэй болох
- Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, устгах системийг бий болгох
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх
- Үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, энэтэй холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулах
- Орчны тохижилт, мод тарих ажлыг жил бүр хийх
- Хийн байгууламжийн ашиглалтын үеийн хийн алдагдлыг хянах дохиолол, заавар зөвлөгөөг байнга дагаж ажилл

“Металл Коппер” ХХК-ийн Улаанбаатар хотын СХД-ийн нутагт орших “Металл хог хаягдлыг дахин боловсруулж, зэс утас үйлдвэрлэх” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх	Машины хатуу хучилттай зогсоол хийх	Төслийн талбай	М2	80,000	60	4,800,000	6 сард	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5914:2008
2.	Уурын зуухны агаарт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах	Агаарын чанар тодорхойлогч суурилуулах	Уурын зуухны барилга байгууламж	ш	600,000	1	600,000	8 сард	
3	Машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Хурд сааруулагч хийх	Төслийн талбайд	ш	100,000	1	100,000	8 сард	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
4	Газрын доорх усыг бохирдох эрсдлээс хамгаалах	Унд ахуйн усны худагт хамагаалалтын бүс тогтоож хашаалах	Өөрийн эзэмшлийн худаг	м	10,000	100	100,000	8 сард	
	Нийт						5,600,000		

5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэрбум хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн хашаанд 50 ширхэг мод тарихаар төлөвлөлөө.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	6	7	8	9
1.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Зүлэг тарих	Үйлдвэрийн хашаанд	М2	10,000	1,000,000	хавар	MNS 5915:2008, MNS 5917:2008, MNS 5918:2008, Биологийн нөхөн сэргээлт хийх журам
2.	Тэрбум модны хөтөлбөрийн дагуу	Мод тарих	Үйлдвэрийн хашаанд	ш	15,000	750,000	9 ссард	Мод, сөөгний үр тарих. Ерөнхий шаардлага MNS 6253-2: 2011
	агаар	Зогсоолд тэмдэг тэмдэглэгээ хийх	Авто зогсоол	машин		500,000	6 сард	
	Нийт					2,250,000		

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай орчим нь олон жилийн туршид хүн суурьшиж ирсэн бөгөөд одоог хүртэл хийсэн археологийн судалгаанаас үзвэл түүхийн олдвор, дурсгалт зүйл газаргүй бөгөөд энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагагүй гэж БОННУ-д үзсэн байна.

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Хийн баллон болон ашиглалтаас үүсэх болзошгүй эрсдэл	Хийн ашиглалтанд байнга мэргэжлийн компаниар хяналт тавиулж ажиллах		Үйл ажиллагааны зардалд суусан				
2	Болзошгүй аюул ослын улмаас гал гарах	Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг байршуулах, галын хор цэнэгтэй эсэхийг байнга шалгаж, цэнэг дууссан үед цэнэглүүлж байх		Үйл ажиллагааны зардалд суусан				Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он Хөдөлмөр хамгаалалын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS4244:1994
3		Галын аюулаас сэрэмжлүүлэх анхааруулга, санамж тэмдэгийг хүний нүдэнд харагдахуйц ил байрлуулах		Үйл ажиллагааны зардалд суусан				
	Нийт							

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	СХД-ийн ТҮК-тэй хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах		удаа					Хог хаягдлын тухай хууль
2	Үйлдвэрийн	Хог хаягдлыг ангилан ялгах стандартийн шаардлага хагнасан түр хадгалах цэг байгуулах		ш	500,000	1	500,000	7 сард	
3		Хог хаягдлыг хувиарын дагуу ачиж төвлөрсөн хогийн цэгт хаях			60,000		60,000	Сар бүр	
1.	Аюултай	-	-		-	-	-	-	-
	Нийт						560,000		

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Металл Коппер” ХХК-ийн Улаанбаатар хотын СХД-ийн нутагт орших “Металл хог хаягдлыг дахин боловсруулж, зэс утас үйлдвэрлэх” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Хөрсний шинжилгээ /хими, физик шинэж чанар/	Үйлдвэрийн хашаа	1цэгээс* 1дээж* 1удаа	1 удаа	50.0	50.000		Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл/ MNS 3985-1987/ Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008.
2	Хөрсний шинжилгээ /хүнд металл/	Үйлдвэрийн хашаа	1цэгээс* 1дээж* 1удаа	1 удаа	50.0	50.000		Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 3297:1991 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS2305 : 1995
3	Усны химийн ерөнхий шинжилгээ Усан дахь бохирдуулагч бодисуудын хэмжээ тодорхойлох	Өөрийн худагаас	1цэгээс*1удаа а*1 дээж	1 удаа	60.000	60.000		Байгаль орчин. Хүний эрүүл мэндийн хамгаалалт. Аюулгүй байдал. Ундны ус. MNS 0900:2018

4	Хорт хий, бохирдуулагч бодисууд: Тоос /PM10, PM2.5/ CO2 502 ^02	Төслийн талбай	1цэгээс*1дээ ж* 1удаа	1 удаа	100.000	100.000	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885:2008 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016
	Нийт					260,000	

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он			
			Cap06	Cap 07		
	1	2	3	4	5	6
1.	БОМТ-ийн төлөвлөгөөг батлагдсан журмын дагуу боловсруулан эрх бүхий байгууллагаар баталуулах, тайлагнах	100.000				
2	Дүүргийн байгаль орчны газараар ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	50.000				
	Нийт	150.000				

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	2025 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг еис.mn сайтаар илгээж Нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлнэ.	цахимаар	2025 оны БОМТ-ийн биелэлтийн тайлан	2025 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө	100.000	Компаний захирал, Байгаль орчны ажилтан	
	Нийт				100.000		

13. ДҮГНЭЛТ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа БОННУ ний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн боловсруулав. Байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн бууруулах, арилгах заавар зөвлөмж, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, давтамж, хөрөнгө зардлыг тусгасан болно.

2025 оны сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээнд 5,600,000 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд 2,250,000 осол, эрсдлийн менежмент төлөвлөгөөнд тусгасан ажилууд нь үйл ажиллагааны төсөвд сууссан, хог хаягдлын менежмент төлөвлөгөө 560,000 байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 260,000, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 150,000, хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх үйл ажиллагаанд 100.000 “Металл коппер” ХХК-ийн БОМТ үйл ажиллагаанд нийт 8.320.000 төгрөгийг хөрөнгө оруулалтыг зарцуулахаар төсөвлөсөн болно